



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Сонгинохайрхан дүүргийн захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын 2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

Аудитын код: НТАГ-2025/032/НА-СТА-ОНӨҮГ

<p>Цахим хуудас: www.audit.mn Улаанбаатар хот 2025 он</p>	<p>Нийслэл дэх Төрийн аудитын газрын дэд дарга: Ч.Болд Утас: 7000-7734 Цахим хаяг: boldch@audit.gov.mn</p> <p>Санхүү, Нийцлийн аудитын хэлтсийн дарга: Х.Түвшинбаяр Утас: 315558 Цахим хаяг: tuvshinbayarkh@audit.gov.mn</p> <p>Аудитын менежер: Я.Алтанцэцэг Утас: 325093 Цахим хаяг: altantsetsegya@audit.gov.mn</p> <p>Аудитыг гэрээгээр гүйцэтгэсэн “Сүлд-Аудит” ХХК-ийн захирал: Ч.Гүндбаяр Утас: 70118016 Цахим хаяг: info@suld-audit.mn</p>
---	---

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



ҮНДЭСНИЙ АУДИТЫН ГАЗАР
НИЙСЛЭЛ ДЭХ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

14200 Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг, 8 дугаар хороо,
Г.Амарын гудамж, Соёлын төв өргөө, Г корпус, 5 давхар,
Утас:7000 7734, Факс: (976-11) 32 01 54
И-мэйл: ub@audit.gov.mn, Вэбсайт: www.audit.mn

2025.03.14 № 01/290
танай _____-ны № _____-т

СОНГИНОХАЙРХАН ДҮҮРГИЙН
ЗАХИАЛАГЧИЙН АЛБА
ОНӨААТҮГ-ЫН ЗАХИРАЛ
Д.АЛТАНХУЯГ ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.8-д заасны дагуу Сонгинохайрхан дүүргийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, орлогын дэлгэрэнгүй, өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан болон нягтлан бодох бүртгэлийн бодлого, тайлбар тодруулгаас бүрдсэн санхүүгийн тайланд аудит хийлээ.

Бидний дүгнэлтээр санхүүгийн тайлангууд нь 2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал болон тайлант жилийн эцсээрх санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаар нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Санхүүгийн тайлагналын олон улсын стандарт (СТОУС)-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт (АОУС), түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу хараат бусаар гүйцэтгэж, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн дагуу "Гэр хорооллын 10,000 айл өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах" төслийн хүрээнд 2021-2024 онуудад нийт 9,203 айл өрхийн нүхэн жорлонг бүрэн шинэчилсэн бөгөөд Сонгинохайрхан дүүргийн Засаг даргын 2024 оны А/07 тоот захирамжаар гэр хорооллын 26 хорооны 3,085 айл өрхийн ариун цэврийн байгууламжийг сайжруулах 9,690.9 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

Аудитын гол асуудал

Тайлант хугацаанд Нийслэлийн засаг даргын 2024 оны А/719 дүгээр захирамжаар "Бэлчээрийн менежмент төслийн нэгж" ОНӨТҮГ-аас балансас балансас нийт 2,527.0 сая төгрөгийг үндсэн хөрөнгийг орлогод авч бүртгэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Байгууллагын 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөнд 4 чиглэл, 8 зорилтын хүрээнд 26 үйл ажиллагааг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс 99.1 хувийн гүйцэтгэлтэй гэж тайлагнасан байна.

Удирдлага болон Засаглах эрх бүхий этгээдийн хүлээх үүрэг, хариуцлага

Удирдлага нь санхүүгийн тайланг Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, СТОУС-ын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ
АУДИТОР



М.ЭРДЭНЭЖАРГАЛ

2. Аудит хийсэн санхүүгийн тайлан

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Дансны код	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН		
1.1	МӨНГӨН ХӨРӨНГӨ		
1.1.1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө	26,320,051.60	70,806,320.64
1.1.2	Дансны авлага	34,408,189.08	3,941,999.20
1.1.3	Татвар, НДШ-ийн авлага		
1.1.4	Бусад авлага		
1.1.5	Бусад санхүүгийн хөрөнгө		
1.1.6	Бараа материал	1,288,162,806.04	2,137,051,904.09
1.1.7	Урьдчилж төлсөн зардал/тооцоо	16,234,229.43	14,677,139.09
1.1.11	Эргэлтийн хөрөнгийн дүн	1,365,125,276.15	2,226,477,363.02
1.2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГӨ		
1.2.1	Үндсэн хөрөнгө	2,044,317,728.19	3,989,794,727.98
1.2.2	Биет бус хөрөнгө	4,643,939.40	38,468,276.78
1.2.4	Урт хугацаат хөрөнгө оруулалт		82,849,647.43
1.2.8	Бусад эргэлтийн бус хөрөнгө		
1.2.10	Эргэлтийн бус хөрөнгийн дүн	2,048,961,667.59	4,111,112,652.20
1.3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН	3,414,086,943.74	6,337,590,015.21
2	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧ		
2.1	ӨР ТӨЛБӨР		
2.1.1	Богино хугацаат өр төлбөр		
2.1.1.1	Дансны өглөг	1,431,465,318.11	1,833,001,750.04
2.1.1.2	Цалингийн өглөг		
2.1.1.3	Татварын өглөг	391,238,992.21	1,003,086,768.32
2.1.1.4	НДШ-ийн өглөг	226,344,275.72	320,791,171.66
2.1.1.8	Урьдчилж орсон орлого	2,239,489,366.90	3,806,353,312.30
2.1.1.13	Богино хугацаат өр төлбөрийн дүн	4,288,537,952.94	6,963,233,002.33
2.1.2.4	Бусад урт хугацаат өр төлбөр		
2.1.2.6	Урт хугацаат өр төлбөрийн дүн		
2.2	Өр төлбөрийн нийт дүн	4,288,537,952.94	6,963,233,002.33
2.3	Эздийн өмч		
2.3.1	Өмч: а) төрийн		
2.3.5	Нэмж төлөгдсөн капитал		
2.3.6	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэл		
2.3.8	Эздийн өмчийн бусад хэсэг		
2.3.9	Хуримтлагдсан ашиг	(874,451,009.20)	(625,642,987.12)
2.3.20	Эздийн өмчийн дүн	(874,451,009.20)	(625,642,987.12)
2.4	ӨР ТӨЛБӨР БА ЭЗДИЙН ӨМЧИЙН ДҮН	3,414,086,943.74	6,337,590,015.21

2.2 Аудит хийсэн орлогын дэлгэрэнгүй тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	Борлуулалтын орлого (цэвэр)	9,060,784,959.07	11,255,424,869.93
3	Борлуулалтын өртөг	370,869,379.02	8,383,807,176.06
4	Нийт ашиг (алдагдал)	8,689,915,580.05	2,871,617,693.87
5	Түрээсийн орлого		
6	Хүүгийн орлого		
7	Ногдол ашгийн орлого		
8	Эрхийн шимтгэлийн орлого		
9	Бусад орлого	4,312,003.06	655,893,368.87
10	Борлуулалт, маркетингийн зардал	6,523,799,645.18	24,000.00
11	Ерөнхий ба удирдлагын зардал	1,932,242,210.27	3,183,568,858.20
12	Санхүүгийн зардал		
13	Бусад зардал	13,706,098.19	67,649,940.01
14	Гадаад валютын ханшийн зөрүүний олз (гарз)		
15	Үндсэн хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		80,000.00
16	Биет бус хөрөнгө данснаас хассаны олз (гарз)		
17	Хөрөнгө орлуулалт борлуулсанаас үүссэн олз (гарз)		
18	Бусад ашиг (алдагдал)		
19	Татвар төлөхийн өмнөх ашиг (алдагдал)	224,479,629.47	276,348,264.53
20	Орлогын татварын зардал	22,447,962.94	27,540,242.45
21	Татварын дараах ашиг (алдагдал)	202,031,666.53	248,808,022.08
22	Зогсоосон үйл ажиллагааны татварын дараах ашиг (алдагдал)		
23	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)	202,031,666.53	248,808,022.08
24	Бусад дэлгэрэнгүй орлого		
25	Хөрөнгийн дахин үнэлгээний нэмэгдэлийн зөрүү		
26	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү		
27	Бусад олз (гарз)		
28	Орлогын нийт дүн	202,031,666.53	248,808,022.08
29	Нэгж хувьцаанд ноогдох суурь ашиг (алдагдал)		

2.3 Аудит хийсэн өмчийн өөрчлөлтийн тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	Өмч	Эздийн өмчийн бусад хэсэг	Хуримтлагдсан ашиг/алдагдал	Нийт дүн
1	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			(1,076,482,675.73)	(1,076,482,675.73)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Залруулсан үлдэгдэл				
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			202,031,666.53	202,031,666.53
5	Бусад дэлгэрэнгүй орлого				
6	Өмчид гарсан өөрчлөлт				
7	Зарласан ногдол ашиг				
8	Дахин үнэлгээний нэмэгдэл				
8	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			(874,451,009.20)	(874,451,009.20)
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт				
3	Залруулсан үлдэгдэл				
4	Тайлант үеийн цэвэр ашиг (алдагдал)			248,808,022.08	248,808,022.08
5	Бусад дэлгэрэнгүй орлого				
6	Өмчид гарсан өөрчлөлт				
7	Зарласан ногдол ашиг				
8	Дахин үнэлгээний нэмэгдэл				
9	2024 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл			(625,642,987.12)	(625,642,987.12)

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

Мөрийн дугаар	Үзүүлэлт	2023 оны 12 дугаар сарын 31	2024 оны 12 дугаар сарын 31
1	Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
1.1	Мөнгөн орлогын дүн (+)	10,458,283,022.85	12,539,060,823.71
1.1.1	Бараа борлуулсан, үйлчилгээ үзүүлсэний орлого	10,439,214,077.85	12,516,993,253.91
1.1.2	Эрхийн шимтгэл, хураамж, төлбөрийн орлого		
1.1.6	Бусад мөнгөн орлого	19,068,945.00	22,067,569.80
1.20	Мөнгөн зарлагын дүн (-)	10,270,150,996.83	12,191,256,554.67
1.2.1	Ажиллагчдад төлсөн	735,298,094.83	1,426,794,389.64
1.2.2	Нийгмийн даатгалын байгууллагад төлсөн	108,477,636.35	338,736,275.72
1.2.3	Бараа материал худалдан авахад төлсөн	8,117,967,276.00	8,554,231,790.07
1.2.4	Ашиглалтын зардалд төлсөн	221,367,490.59	289,913,204.00
1.2.5	Түлш, шатахуун, тээврийн хөлс, сэлбэг хэрэгсэлд төлсөн	736,634,463.06	1,185,323,551.00
1.2.6	Хүүний төлбөрт төлсөн		
1.2.7	Татварын байгууллагад төлсөн	193,016.00	4,607,968.00
1.2.8	Даатгалын төлбөрт төлсөн	610,875.00	6,868,355.00
1.2.9	Бусад мөнгөн зарлага	349,602,145.00	384,781,021.24
1.3	Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	188,132,026.02	347,804,269.04
2	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
2.1	Мөнгөн орлогын дүн (+)		80,000.00
2.1.1	Үндсэн хөрөнгө борлуулсаны орлого		80,000.00
2.1.2	Биет бус хөрөнгө борлуулсаны орлого		
2.1.6	Хүлээн авсан хүүний орлого		
2.2	Мөнгөн зарлагын дүн (-)	179,151,400.00	303,398,000.00
2.2.1	Үндсэн хөрөнгө олж эзэмшихэд төлсөн	179,151,400.00	303,398,000.00
2.2.2	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн		
2.3	Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн	(179,151,400.00)	(303,318,000.00)
3	Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ		
3.1	Мөнгөн орлогын дүн (+)		
3.1.1	Бусад		
3.2	Мөнгөн зарлагын дүн (-)		
3.2.1	Бусад		
3.2.2	Санхүүгийн түрээсийн өглөгт төлсөн		
3.3	Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээний дүн		
4	Бүх цэвэр мөнгөн гүйлгээ	8,980,626.02	44,486,269.04
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	17,339,185.58	26,320,051.60
6	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	26,320,051.60	70,806,320.64

2.5 Эдийн засгийн үзүүлэлт, зорилтот түвшний гүйцэтгэл

2024 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр дуусгавар болсон

/төгрөгөөр/

№	Үзүүлэлт	2023 оны гүйцэтгэл	2024 оны төлөвлөгөө	2024 оны гүйцэтгэл	Зөрүү		
					+хэмнэсэн	-хэтэрсэн	
	НИЙТ ЗАРЛАГА БА ЗЭЭЛИЙН ДҮН						
	Ашиг	202,031,666.53	2,223,225.00	248,808,022.08	(246,584,797.08)		11,191.3
	БАРАА АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	8,863,065,295.60	12,713,129,275.00	11,662,590,216.72	1,050,539,058.28		91.7
1.1	Цалин хөлс болон нэмэгдэл урамшуулал	889,807,180.00	1,817,315,000.00	1,785,851,712.16	31,463,287.84		98.3
	Үндсэн цалин		1,683,800,000.00	1,785,851,712.16	(102,051,712.16)		106.1
	Унаа хоолны хөнгөлөлт		133,515,000.00	-	133,515,000.00		0.0
1.2	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	119,167,904.84	263,510,675.00	236,423,526.96	27,087,148.04		89.7
	Тэтгэврийн даатгал		172,644,925.00	148,859,257.71	23,785,667.29		86.2
	Тэтгэмжийн даатгал		14,538,520.00	14,010,283.08	528,236.92		96.4
	ҮОМШӨ-ний даатгал		36,346,300.00	35,025,707.70	1,320,592.30		96.4
	Ажилгүйдлийн даатгал		3,634,630.00	3,502,570.77	132,059.23		96.4
	Эрүүл мэндийн даатгал		36,346,300.00	35,025,707.70	1,320,592.30		96.4
1.3	Борлуулалт маркетингийн зардал	6,894,669,024.20	9,015,816,500.00	8,450,535,276.08	565,281,223.92		93.7
	Маркетингийн зардал		2,600,000.00	-	2,600,000.00		0.0
	Борлуулалтын зардал	6,894,669,024.20	9,013,216,500.00	8,450,535,276.08	562,681,223.92		93.8
1.4	Байр ашиглахтай холбоотой тогтмол зардал	25,025,000.00	66,140,000.00	34,050,000.00	32,090,000.00		51.5
	Байрны түрээс		30,000,000.00	30,850,000.00	(850,000.00)		102.8
	Автомашины зогсоолын түрээс	15,000,000.00	24,000,000.00	-	24,000,000.00		0.0
	Санхүүгийн программын түрээсийн	10,025,000.00	12,140,000.00	3,200,000.00	8,940,000.00		26.4
1.5	Хангамж бараа материалын зардал	824,254,085.43	1,173,896,600.00	1,031,595,552.61	142,301,047.39		87.9
	Бичиг хэрэг	8,600,290.37	16,407,600.00	9,327,547.26	7,080,052.74		56.8
	Тээвэр шатахуун	812,888,581.84	1,154,495,000.00	1,016,215,943.60	138,279,056.40		88.0
	Шуудан холбоо, интернетийн төлбөр	2,765,213.22	2,994,000.00	3,949,584.46	(955,584.46)		131.9
	Бусад бараа ажил үйлчилгээний зардал		-	2,102,477.29	(2,102,477.29)		
1.6	Нормативт зардал	67,469,400.00	59,610,000.00	73,406,093.91	(13,796,093.91)		123.1
	Эм бэлдмэл эмнэлгийн хэрэгсэл	6,300,000.00	6,700,000.00	2,171,653.00	4,528,347.00		32.4
	Сургалт	3,000,000.00	5,000,000.00	-	5,000,000.00		0.0
	Нормын хувцас хэрэглэл	28,569,400.00	27,510,000.00	45,886,459.09	(18,376,459.09)		166.8
	Эд хогшил урсгал засвар	25,000,000.00					
	Багаж хэрэгсэл	4,600,000.00	20,400,000.00	25,347,981.82	(4,947,981.82)		124.3
1.7	Удирдлагын зардал	13,706,098.19	15,000,000.00	9,649,940.01	5,350,059.99		64.3
1.8	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардал	6,518,640.00	12,640,500.00	13,537,872.54	(897,372.54)		107.1
	Төв замын зөвшөөрөл		780,000.00	-	780,000.00		0.0
	Даатгал	5,250,000.00	5,250,000.00	6,480,086.36	(1,230,086.36)		123.4
	Тээврийн хэрэгслийн татвар		5,450,500.00	6,067,786.18	(617,286.18)		111.3
	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,268,640.00	1,160,000.00	990,000.00	170,000.00		85.3
1.9	ААНОАТ-ын зардал	22,447,962.94	-	27,540,242.45	(27,540,242.45)		

**Сонгинохайрхан дүүргийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

1.10	Хөрөнгийн зардал	368,561,817.54	289,200,000.00	290,598,181.82	(1,398,181.81)	100.5
	Барилга байгууламж	361,036,363.00	255,000,000.00	290,598,181.82	(35,598,181.81)	114.0
	Тоног төхөөрөмж	7,525,454.54	34,200,000.00		34,200,000.00	0.0
1.11	Өмнөх оны өр төлбөр		1,460,000,000.00	3,150,259,930.71	(1,690,259,930.71)	215.8
	НДШ өглөг		120,000,000.00	314,171,412.34	(194,171,412.34)	261.8
	Татварын өглөг		150,000,000.00	1,003,086,768.33	(853,086,768.33)	668.7
	Бусад өглөг		1,190,000,000.00	1,833,001,750.04	(643,001,750.04)	154.0
1.12	Тайлант үеийн өр төлбөр			27,540,242.45	(27,540,242.45)	
2	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	9,065,096,962.13	12,715,352,500.00	11,911,398,238.80	803,954,216.20	93.7
	Инженерийн хяналтын орлого	318,181,818.18	500,000,000.00	745,454,545.45	(245,454,545.45)	149.1
	Бохир сорох үйлчилгээний орлого	941,806,053.04	1,355,000,000.00	927,364,461.47	427,635,538.53	68.4
	Нүхэн жорлонгийн төслийн орлого	7,230,000,000.00	9,719,352,500.00	9,148,693,182.00	570,659,318.00	94.1
	Нүхэн жорлонгийн сервис үйлчилгээний орлого	284,2я00,000.00	341,000,000.00	101,458,224.76	239,541,775.24	29.8
	Ариутгалын үйл ажиллагааны орлого	290,909,090.91	200,000,000.00	24,463,818.00	175,536,182.00	12.2
	Өвсний орлого		600,000,000.00	308,070,638.25	291,929,361.75	51.3
	Бусад орлого			655,893,368.87	(655,893,368.87)	

3. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Аудитаар нийт 3,642,247.4 мянган төгрөгийн 12 алдаа илэрснийг аудитын явцад залруулсан.

Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Алдааны товч утга	Нийт алдаа		Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан		Буруу тусган илэрхийлсэн		Үүнээс				Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Залруулсан		Залруулаагүй		Тоо	Дүн
							Тоо	Дүн	Тоо	Дүн		
Дээд газрын захирамжийн дагуу хөрөнгүүдийг балансаас балансад шилжүүлж бүртгэхдээ эздийн өмчийн бусад хэсэг дансыг энэ дүнгээр нэмэгдүүлж бүртгэсэн.	1	2,102,255.3			1	2,102,255.3	1	2,102,255.3				
Урьдчилж орсон орлого дансанд 2024 оны 01 дүгээр сарын 01-ний байдлаар үлдэгдэлтэй байсан хөрөнгийг эздийн өмчийн бусад хэсэгт шилжүүлэн бүртгэсэн.	1	1,010,599.7			1	1,010,599.7	1	1,010,599.7				
Бусад байгууллагаас шилжин ирсэн хөрөнгийн элэгдлийг илүү дүнгээр бүртгэсэн.	1	88,049.2			1	88,049.2	1	88,049.2				
Машин тоног төхөөрөмжийн дансанд үндсэн хөрөнгийн ангилал зөрүүлж 67,747.0 мянган төгрөгийн компьютер дагалдах хэрэгслийг бүртгэсэн.	1	67,747.0			1	67,747.0	1	67,747.0				
Хоёрдогч түүхий эдийг зарж борлуулсан 30 хувийг бүртгэлд тусгаагүй байна.	1	80.0			1	80.0	1	80.0				
Өр төлбөр дансыг 34,500.0 мянган төгрөгөөр буруулах бичилт хийсэн.	1	34,500.0			1	34,500.0	1	34,500.0				
Цалингийн зардалд 5,023.0 мянган төгрөгийн засварын болон зам ашигласны зардлыг бүртгэсэн. Нийт цалингийн зардлыг нийгмийн даатгалын тайланд 63.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан.	1	5,086.0			1	5,086.0	1	5,086.0				
Нэмэгдсэн ертгийн албан татварын	1	5,018.0			1	5,018.0	1	5,018.0				

**Сонгинохайрхан дүүргийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан**

тайланд орлогыг 5,018.0 мянган төгрөгөөр дутуу тайлагнасан байна												
Үнэ төлбөргүй хүлээн авсан 68,512.3 мянган төгрөгийн мал амьтдыг бараа материалд бүртгэсэн.	1	68,512.3			1	68,512.3	1	68,512.3				
Газрын эрхийн бичгийг газар сайжруулалтаар тайлагнасан	1	36,659.4			1	36,659.4	1	36,659.4				
Машин тоног төхөөрөмжийн их засварын зардлыг тайлант хугацааны зардлаар бүртгэсэн.	1	203,483.4			1	203,483.4	1	203,483.4				
Татварын өглөг нь татварын тодорхойлолтын дүнгээс 20,257.1 мянган төгрөгөөр дутуу байна..	1	20,257.1			1	20,257.1	1	20,257.1				
Дүн	12	3,642,247.4			12	3,642,247.4	12	3,642,247.4				

Аудитаар нийт 117,397.3 мянган төгрөгийн 8 зөрчил илэрснээс, 4,000.0 мянган төгрөгийн 1 төлбөрийн акт тогтоож, 22,233.3 мянган төгрөгийн 1 албан шаардлага хүргүүлж, 91,164.0 мянган төгрөгийн зөрчлийг давтан гаргахгүй байх 6 зөвлөмж өгсөн.

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		/мянган төгрөгөөр/									
			Үүнээс									
	Төлбөрийн акт	Албан шаардлага	Зөвлөмж		Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал					
Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн	
Бараа материалын дансыг мал амьтдын өвс тэжээлд зарцуулсан 18,528.8 мянган төгрөгөөр нас дэвшилтийн орлого нэрээр нэмэгдүүлсэн.	1	18,528.8					1	18,528.8				
Тайлант онд 56,179.2 мянган төгрөгийн ибаримтгүй худалдан авалт хийсэн байна.	1	56,179.2					1	56,179.2				
НӨХГ-ын зөвшөөрөлгүй 15,800.0 мянган төгрөгийн тээврийн хэрэгслийг худалдан авсан.	1	15,800.0					1	15,800.0				
Үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй	1	-					1	-				

Сонгинохайрхан дүүргийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 3 нэр төрлийн 112 ширхэг хөрөнгийг бодит үнэ цэнээр нь үнэлж бүртгээгүй байна.												
Дээд газрын захирамжаар орон нутгийн өмчит төслөөс балансаас балансад шилжиж ирсэн цаашид ашиглах боломжгүй 69 нэр төрлийн 22,233.3 мянган төгрөгийн хөрөнгийг санхүүгийн тайландаа орлого авч бүртгэсэн.	1	22,233.3			1	22,233.3						
ХХОАТ-ын хөнгөлөлтийн тооцоог буруу хийснээс 6 ажилтанд хөнгөлөлт дутуу эдлүүлсэн байна.	1	636.0					1	636.0				
Анхан шатны нотлох баримтгүйгээр 4,000.0 мянган төгрөгийн сэлбэг хэрэгсэл худалдан авсан байна.	1	4,000.0	1	4,000.0								
Улсын бүртгэлийн гэрчилгээн дээр өөрийн хөрөнгийн хэмжээ 20.0 мянган төгрөг байгаа боловч санхүүгийн тайланд тайлагнаагүй .	1	20.0					1	20.0				
Дүн	8	117,397.3	1	4,000.0	1	22,233.3	6	91,164.0				

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

Нийцлийн аудитын асуудлаар илэрсэн нийт 7,239,304.9 мянган төгрөгийн зөрчилд 3 зөвлөмж өглөө.

Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Үүнээс					
			Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн	Тоо	Дүн
Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил								
Шилэн дансны цахим хуудаст цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын 714,549.2 мянган төгрөгийн 14 гүйлгээ, зарлагын 2,119,652.0 мянган төгрөгийн 21 гүйлгээг байршуулаагүй байна.	1	2,834,201.2					1	2,834,201.2
Бусад хууль тогтоомжтой холбоотой зөрчил								
Худалдан авалтын төлөвлөгөөнд батлуулаагүй, цахим дэлгүүрийн	1	1,310,661.5					1	1,310,661.5

Сонгинохайрхан дүүргийн Захиалагчийн алба ОНӨААТҮГ-ын
2024 оны санхүүгийн тайланд хийсэн аудитын тайлан

захиалга өгөөгүй 19,100.0 мянган төгрөгийн хөрөнгө,1,291,561.5 төгрөгийн бараа материалыг шууд худалдан авсан.								
Богино хугацаат өр төлбөр дансны үлдэгдэл 3,094,442.2 мянган төгрөг болж өмнөх оноос 66.2 хувиар өссөн байна. Үүнээс татварын байгууллагад 1,330,464.4 мянган төгрөг, хөрөнгө оруулалтын санхүүжилтээ орон нутгийн төсвөөс авсан боловч барааны үлдэгдэл төлбөрийг төлж барагдуулаагүй 1,310,084.5 мянган төгрөгийн өр төлбөрүүд байна	1	3,094,442.2					1	3,094,442.2
Нийт дүн	3	7,239,304.9					3	7,239,304.9